



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/71

Хэрлэн сум

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвөөс худалдаж авсан тавилга, Засаг даргын нөөц хөрөнгөөр худалдан авсан компьютер тоног төхөөрөмж, Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 315 дугаарт албан бичгийн дагуу 20тн бүхий 12 ширхэг контейнер, 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн №1/10 дугаартай гэрээний дагуу худалдан авсан NISSAN NV200 маркийн автомашиныг үндсэн хөрөнгөд тус тус бүртгэсүгэй.

2. Дээрх хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д, тоног төхөөрөмжид карт хөтөлж, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллахыг Нярав (Т.Баяртуяа)-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА